



ДУНДГОВЬ АЙМАГ
ӨНДӨРШИЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 01

Бөхт

Сумын ОНХС-ийн 2016 оны тодотгосон
төсвийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "Б", Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2, 65.1.1 дэхь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэгийг 162492,7 мянган төгрөг, шилжих хөрөнгө оруулалтыг 42268,7 төгрөг, нийт 204702,4 мянган төгрөгөөр тодотгон баталсугай.
2. Орон нутгийн хөгжлийн сангаар 2016 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Сумын ИТХ-ын 2015 оны 12 сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 7.4 дэх заалт болон 9 дэх заалтаар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
4. Тодотгосон зарлага санхүүжилтийг хууль журамд нийцүүлэн зарцуулж тайлагнахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, сумын Засаг дарга Н.Мөнхцэцэгт даалгасугай.

ДАРГА



О.ЦОЛМОН

010000096

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02
сарын 26 ны өдрийн 01 тоот тогтоолын хавсралт

ӨНДӨРШИЛ СУМЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨТӨЛБӨР ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
ЖАГСААЛТ

Д/д	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Мөрийн дугаар	Эхлэх дуусах хугацаа	Төсөвт өртөг /төгрөгөөр/	2015 онд санхүүжүү -лэх дүн
0	1	2	3	4	5
1	Ахмадын байрны засвар	1	2015-2016	34500000	34500000
2	Хүүхдийн цэцэрлэгийн барилгын дотор цэвэр, бохир усны шугам, гадна бохир усны цооног шинээр байгуулах	2	2016	56761439	56761439
3	Инженерийн хийцтэй худаг гаргах 1-р баг Ухаа худаг, Хэрээ, 2-р баг Улаан толгой, Шар хоолой Нийт 4 худаг	3	2016	30000000	30000000
4	Аймгийн цэнгэлдэх хүрээлэн, Мандалговь цэцэрлэгт хүрээлэн байгуулах /гадна дулаан, цахилгаан, цэвэр, бохир ус, гадна зам талбайн ажил/	4	2016	50000000	50000000
5	Цахим аймаг /камержуулалт, интернет 2 жилийн эрх/	5	2016	11000000	11000000
6	Сумын адууны генетикийн шинжилгээ	6	2016	3000000	3000000
7	Үндэсний их баяр наадам	7	2016	5000000	5000000
8	2-р багийн Өлзийтийн энгийн уурхайн худаг засвар	8	2016	1500000	1500000
9	Сумын төвийн гэрэлтүүлгийн өргөтгөл	9	2016	10000000	10000000
10	Соёлын төвийн шалны засвар	10	2016	2940997	2940997
	Дүн			204702436	204702436

СУМЫН САНХҮҮГИЙН АЛБА